



МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН САЙДЫН
ТУШААЛ

2015 оны 11 сарын 27 өдөр

Дугаар 319

Улаанбаатар хот

Журамд нэмэлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Авто замын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Зам, тээврийн сайдын 2013 оны 152 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Авто зам, замын байгууламжийг барих, засварлах тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох журам"-ын 5 дугаар зүйлийн 5.2 дахь заалтад доорх заалтыг нэмсүгэй. Үүнд:

"5.2.8 "Салбарын норматив баримт бичгийн тогтолцоог боловсронгуй болгох сан"-д хөрөнгийг хуульд заасан хувь хэмжээгээр төвлөрүүлсэн баримт".



• 081229